

SOME ISSUES IN THE STUDY OF ANCIENT SOURCES ON ETHICS

(Based on Aristotle's "Nicomachean Ethics")

Ulziisaikhan Ishgombo^{1*}, Chuluunbaatar Jigmeddor²

Doctor (Ph. D), Lecturer, Department of the Social Sciences,
Mongolian National Defense University, Ulaanbaatar, Mongolia

DOI: <https://doi.org/10.65902/tsats.2026.02.012>

ARTICLE INFO:

RECEIVED: 06 March 2026

ACCEPTED: 28 April 2026

PUBLISHED: 02 June 2026

LICENSE:



Creative Commons CC-BY 4.0

COPYRIGHT:

© 2026. The author(s)

This publication is an open-access article.

CORRESPONDING AUTHOR:

*Ulziisaikhan Ishgombo

KEYWORDS:

Person, magna moralia, morality, ethics, state, politics, society, middle point, golden mean, law, emotion, mind, justice, beauty, courage, stingingness, health

Abstract:

The Greek philosopher Aristotle (384-322 BC) conducted extensive research across many disciplines and wrote important works on morality, including ideas that are still valuable today.

Therewith, he made a significant contribution to the development of moral thought by systematically and theoretically raising principles.

Here, we select "Magna Moralia" from among his works and analyze its theme and significance.

Introduction

Literature Review: Aristotle was born in the city of Stagira on the coast of Thrace, into a family of physicians. His father was the court physician to King Amyntas III of Macedon. Aristotle's proximity to medicine may have influenced his moral perspectives. He wrote an ethical trilogy: "Nicomachean Ethics," "Eudemian Ethics"¹, "Magna Moralia"².

All three of these works discuss human and social morality. Therefore, researchers believe that there are numerous related concepts and parallel thinking between these works. The selected work was written later than the first two. Researcher

¹ "Moral doctrine delivered by Students" – Eudemus is a student of Aristotle.

² "Эцгээрээ дамжуулан хэлэх ёс зүй"

Dash-Yondon Y. suggests that the work was named "Magna" as a dedication to the Neoplatonist Nicomachus of Elis, Aristotle's father; henceforth, it could be translated into Mongolian as "Moral doctrine delivered by Father/ Эцэг хүнээр дамжуулж хэлэх суртахууны номлол."³ Researchers have noted the following opinions about the work: "It is the first work that fully reflects Aristotle's ethical teachings" W. Tyler, (1934), "This work is an elaborated version of another brief work" O. Zhigan, (1951), "The chapters of the work are thicker than those of the other two" P. Moreau (1951), "The work contains a 'great and important ' principle' Chr. Panch, and "The work covers more topics than the other two," Albert the Great.

Researcher B. Oyunchimeg remarked that "Although Aristotle only wrote a single work in several scientific fields, including physics, metaphysics, psychology, and politics, he wrote three major works on morality and its basic concepts: "Magna Moralia," "Nicomachean Ethics," and "Eudemian Ethics," which shows that he thoroughly inferred and realized the importance of morality in the fate of humanity."⁵ The Russian scholar Arseny Nikolaevich Chanyshev (1926-?) cited in his neatly simplified pamphlet "Aristotle" (M., 1981, 1987): "Aristotle decisively distinguished ethics, which is a practical science, and the closely related political science, from theoretical and meditative science. Practical science is the science of action, which is related to the free choice of a person who is responsible for his behavior."⁶

Aims

In light of the above, Aristotle's works on ethics are more practical than theoretical ones, and they reflect on many ethical issues such as human action, responsibility, and right decisions of life, deeply contemplating the moral foundations of a person and society. In "Magna Moralia", he wrote that "Plato ... seems to employ proportional justice in his 'Republic'. For the farmer, he says, produces food, and the housebuilder a house, and the weaver a cloak, and the shoemaker a shoe.

Now the farmer gives the to housebuilder food, and the housebuilder gives the farmer a house; and in the same way, all the rest exchange their products against those of others. And this is the proportion. As the farmer is to the housebuilder, so is the housebuilder to the farmer. In the same way as the shoemaker, the weaver, and all the rest, the same proportion holds towards one another.

And this proportion holds the commonwealth together. So that the just seems to be the proportional. For the just holds commonwealths together, and the just is the same thing as the proportional."⁷ Here Aristotle quotes from Plato's "Republic" and discusses the nature of justice. Thus, he determined that human life, social structure, and the concept of justice, which are a single modus operandi of the city-state and politics, are closely interconnected and that the entire system is based on balance/ proportion and harmony. The underlying principles of society and politics are based on justice, which

⁴ Dash-Yondon B. Sources of Ancient Greek Philosophical Thought. Volume II. UB., 2011. Page 16

means that it is expressed through the proportional regulation of all elements involved in social relations.

When Aristotle defined ethics at the beginning of his work "Magna Moralia", he emphasized its direct socio-political significance, saying, "Ethics are an integral part of the state. ... It is absolutely unnecessary to involve a person who lacks certain moral qualities, namely, an incompetent person, in political and public affairs."⁸

Socio-political life is created and exists based on the complex relationships between many interdependent components. Its unit modus is each person, who, with the help of morality, creates their own social interdependent environment. The interdependent environment must be balanced and fair/ just. Being fair in dealing with people is fundamentally an act of equality.

In the work, it is mentioned that "the just is equal, the proportionally equal will be just. Now proportion implies four terms at least: meaning that A must be related to B in the same way that G is related to D. For instance, it is proportional that he who has much should contribute much, and that he who has little should contribute little; again, in the same way, that he who has worked much should receive much, and that he who has worked little should receive little.

The industrious has the same relationship to the lazy (the industrious gets more, the lazy gets less), and the lazy has the same relationship to the little (the industrious gets the more)." ⁹ If A or D, or one or a part of it, becomes more dominant, the balance/proportion in society will be lost, it will escalate the establishment of justice, and it will be unfeasible for the society to properly form the fundamental principles of politics.

It contains the idea that every segment of society, every citizen of the city -state, can live well, the state be strong, and develop rapidly by fulfilling their duties properly and creating balanced ethical relationships with each other.

Aristotle wanted to convey the idea that justice is not only manifested in law, but also in the morally balanced relationship between citizens, in the symmetry of proper harmony. In other words, socio-political life is a matter of morally fulfilling and balanced relationships between people/citizens.

This balance should not be based on the excess of power or resources on any one side, but on a balanced distribution and fair relations for all parties. As mentioned above, justice does not only exist in the law, but also in creating these balanced relationships

Aristotle's "Magna Moralia" is structured in the form of an encyclopedic dictionary of ethical terms. The author focuses more on the practical wisdom inherent in the subtle nature of life, while providing detailed explanations of each unit. In the first book (A), chapter 34 explains the deep meanings of ethical terms such as ethics, goodness, goodness in the mind, good deeds, thoughts, pleasures and pains, what lies

⁸ Aristotle. Magna Moralia. First Book (A) (1). Dash-Yondon B. Sources of Ancient Greek Philosophical Thoughts. Volume II. UB., 2011. Page 20

⁹ Aristotle. Magna Moralia. First Book (A) (1). Dash-Yondon B. Sources of Ancient Greek Philosophical Thoughts. Volume II. UB., 2011. Page 52

deep in the mind, average, being above and below average, the beginning, man, voluntary action, disorder, compulsion, inevitability, involuntary, free choice, intelligence, great beauty, courage, sound mind, steadfastness, generosity, stinginess, nobility, generosity, lust, sense of propriety, humility, playfulness, friendliness, truthfulness, justice, health, etc., based solely on real life and practical knowledge.

Aristotle, in explaining above terms, wanted to define the moral nature of human life from a philosophical perspective, demonstrating the meaning of human life, the importance of morality, how emotional state affect one's character and own life, how good and bad human actions reflect one's existence in society and determine the nature of politics and society, how good deeds can bring positive change to everyone's life, living the right way, respecting others, practicing justice, improving oneself, being generous and respecting the freedom of others, and doing good deeds. He comprehensively described the human species from a moral perspective, starting with its inner nature as a social unit, and wrote in many ways that the results of its good and bad deeds ultimately reflect its political nature.

For instance, he wrote "...If therefore one is to act successfully in affairs of state, one must be of a good moral character. The treatment of moral character, then, is, as it seems, a branch and starting-point of statecraft. And as a whole it seems to me that the subject ought rightly to be called, not Ethics, but Politics...."¹⁰

The entire work provides a comprehensive and detailed account of what a highly ethical person is like according to the explanation of ethical terms in Book 1 (A) 34 of Aristotle's "Magna Moralia".

The reader or researcher who has read and comprehended the work will perceive that a human being is not just a biological animal, but also a "political animal" who can understand and live by the ethics, character, intellect, emotions, meaning of life, and values accumulated throughout human history, maintain the "Golden Mean" balance of mind and heart, have a positive influence on others, and perform the right actions. Therefore, it is appropriate that this work, which has become the foundation of ethical science, should be used as a primary source of study and understanding by all young people, audiences, and students who are pursuing higher education.

The work clearly states that citizens need to follow high ethical standards, such as a deep perception of human rights and wrongs, the difference between good and evil, and the average of their norms, justice, generosity, respect, faith, forgiveness, gentleness, following the right moral direction, making the right choices in life, and respecting the rights of others.

Originality

Even in modern times, personal morality is the foundation for interacting properly with the society in which we live, establishing good relationships with others, working honestly and acceptance by respecting the rights of others. Making the right

¹⁰ Aristotle. *Magna Moralia*. First Book (A) (1). Dash-Yondon B. Sources of Ancient Greek Philosophical Thoughts. Volume II. UB., 2011. Page 20

choices in life, maintaining one's emotional balance, consciously fulfilling one's responsibilities, and respecting the environment in which one lives are part of one's moral maturity and development. Therefore, Aristotle's "Magna Moralia," which aptly explains how high morality is the foundation for strengthening a person's high level of spirituality and position in social life, has not lost its value and significance even today in this regard.

General Conclusion

Hence, we concluded the following, considering the theme and significance of Aristotle's "Magna Moralia". In addition, it is essential to study it repeatedly from many aspects and to demonstrate its value and importance to young people.

- Aristotle mainly emphasized that morality is a practical and scientific ability in the "Magna Moralia." He thoroughly analyzed moral issues through philosophical thinking and comprehensively demonstrated what it means to be a human being, a political animal.
- The work is not only about morality, but also contains socio-political concepts in a subtle way, which is clearly evident from the countless sections related to government and politics, and their relations. Therefore, it is important and necessary to study the work from the perspective of political science. Furthermore, we may conclude that anthropology, psychology, and linguistics research can be done through the work.
- Aristotle mentioned that if a person wants to participate in political activities and govern the state, he must first have a good understanding of the magna moralia, master them in reality/ daily, and have a great knowledge of the mind, behavior, and ethics.
- Aristotle wrote his ideas about morality not only in this work but also in many other works, such as "Politics", "Rhetoric", and "Emotions". And although there are differences of opinion on some points, Plato's socio-political teachings influenced his writings. Therefore, to fully understand the nature of Aristotle's ethical concepts, it is crucial to study Plato's ideas in parallel.
- Aristotle, in his work "Magna Moralia", while developing ethical issues, defined the nature and content of the relationship between man and politics. The study of ethical philosophy was of great help to him in rationally explaining the nature of the state. Leo Strauss, American scholar of political philosophy, wrote in his evaluation of Aristotle's works on ethics, "We may consider Aristotle's "Ethics" (here referring to Aristotle's 'Magna Moralia' and two other works on the subject) as the most perfect, or perhaps the most rationally and intelligibly philosophized ethics".¹¹
- Aristotle was a brilliant scholar and expert, who was very precise in defining basic ethical terms, was very skilled in defining phenomena and concepts, and seemed to have his own unique research methods. His works are closely interconnected, and all of them seem to have some level of ethical concern embedded in them. For

example, in the context of my reading and research, "Politics," "Rhetoric," "Magna Moralia," and two other works on the subject of ethics are closely related in their ethical content.

References:

- [1] Aristotle. Politics. Dash-Yondon B. Sources of Ancient Greek Philosophical Thoughts. Volume I. UB., 2011.
- [2] Aristotle. Politics. UB., 2015.
- [3] A.N.Chanyshv. Aristotle. M., 1981, 1987 Dash-Yondon B. Sources of Ancient Greek Philosophical Thoughts. Volume I. UB., 2011.
- [4] Aristotle. Magna Moralia, Dash-Yondon B. Sources of Ancient Greek Philosophical Thought. Volume II. UB., 2011.
- [5] Aristotle. Rhetoric, Dash-Yondon B. Sources of Ancient Greek Philosophical Thought. Volume III. UB., 2011.
- [6] Tsanjid A. Political Science. UB., 2010.
- [7] Oyunchimeg B. A book on Ethics and Morality. UB., 2019.
- [8] Ulziisaikhan I. Analysis on the content of Aristotle's "Rhetorica" AE. Ulaanbaatar School of NUM, Faculty of Social Sciences, Department of Humanities Scientific Bulletin No. 2(1). UB., 2011.
- [9] Philosophy. Textbook. UB., 2002.
- [10] Sh. Gankhuyag, M. Gantuyaa. Historical review of philosophy. UB., 2002.

**Ёс суртахууны тухай эртний сурвалжид хийгдсэн
судалгааны зарим асуудал**
(Аристотелийн “Дээд суртахуун” зохиолын жишээн дээр)

Ишгомбын Өлзийсайхан¹, Жигмэддоржийн Чулуунбаатар²

Нийгмийн ухааны тэнхим

Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй. Грекийн философич Аристотель (МЭӨ 384-322) олон салбарыг хамарсан цар хүрээ өргөн судалгаа явуулж өнөөдөр ч үнэ цэнэтэй санаанууд дэвшүүлсний дотроос ёс суртахууны талаар чухал зохиолуудыг бичжээ. Тэрээр ёс суртахууны үзэл санааг системчлэн онолын түвшинд хүргэснээрээ ёс зүйн сэтгэлгээний хөгжлийн түүхэнд томоохон хувь нэмрийг оруулсан байна. Энд түүний зохиолууд дундаас “Дээд суртахуун” зохиолыг сонгон авч агуулга, ач холбогдлыг шинжлэхийг зорилгоо болгов.

Түлхүүр үг: Хүн, дээд суртахуун, ёс суртахуун, ёс зүй, төр, улс төр, нийгэм, дундаж, алтан дундаж, хууль, сэтгэл, оюун ухаан, шударга ёс, сайхан, эр зориг, харамч, эрүүл мэнд

Оршил

Судлагдсан байдал: Аристотель Фракийн эрэг дэх Стагир хотод эмчийн гэр бүлд төржээ. Эцэг нь III Амюнтас Македон хааны ордны эмч байв. Анагаах ухаантай ойрхон байсан нь Аристотелийн ёс суртахууны сэтгэлгээний хөгжилд нөлөөлсөн байж болох талтай. Тэрээр ёс зүйн гурвансан зохиол болох “Никомахын ёс зүй”⁶, “Евдемийн ёс зүй”⁷, “Дээд суртахуун”⁸-ыг туурвисан. Эдгээр гурван зохиолын аль алинд хүн ба нийгмийн ёс суртахууны тухай яригдаж буй ба энэ утгаараа эдгээр зохиолуудын хооронд ижил санаа, нийтлэг үндэслэл их байдаг хэмээн судлаачид үздэг байна. Сэдэвт сонгон авсан зохиол эхний хоёроосоо хожим бичигдсэн байна. Судлаач Ё.Даш-Ёндон уг зохиолын тухай шинэ платонч Элийн Ахмад Никомахад, өөрөөр хэлбэл Аристотелийн эцэгт зориулагдсан хэмээн хэлсний үндэслэл болгож зохиолыг “Том” гэсэн нэр авсан, Монгол хэлээр “Эцэг хүнээр дамжуулж хэлэх суртахууны номлол”⁹ гэж орчуулж болох юм гэсэн санааг дэвшүүлжээ. Мөн энд тусгагдсан зохиолын тухай судлаачдын үзэл санаа нь, В.Тайлер “Энэ зохиол нь Аристотелийн ёс зүйн номлолоо бүрэн дүүрэн тусгасан анхны бүтээл” (1934), О.Жиган “Энэ зохиолыг бүүр товчхон өөр нэг номноос дэлгэрүүлэн гаргаж авсан” (1951), П.Моро “Энэ номын бүлгүүдийг бусад хоёрынх нь бүлгүүдтэй харьцуулахад илүү зузаан” (1951), Хр.Панш “Энэ зохиолд “аугаа том”, нэн чухал номлол сургаал орсон”, Их Альберт “Уг зохиолд бусад хоёроос илүү олон сэдэв хөндөгдсөн” гэж тус тус тэмдэглэн үлдээжээ.

⁶ “Хүүгээрээ дамжуулан хэлэх суртахууны номлол” - Никомах бол Аристотелийн хүү.

⁷ “Туслагч шавь нараар дамжуулан хэлэх ёс зүй” – Евдем бол Аристотелийн шавь.

⁸ “Эцгээрээ дамжуулан хэлэх ёс зүй”

⁹ Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. УБ., 2011. Тал 16.

Судлаач Б.Оюунчимэг “Аристотель физик, метафизик, сэтгэл судлал, улс төр зэрэг хэд хэдэн шинжлэх ухааны чиглэлээр зөвхөн ганц ганцхан бүтээлтэй ч ёс суртахуун, түүний үндсэн ойлголтуудын тухай “Дээд суртахуун”, “Никомахын ёс суртахуун”, “Евдемийн ёс суртахуун” гэсэн гурван томоохон зохиол туурвисан нь хүн төрөлхтний хувь заяанд ёс суртахуун ямар их ач холбогдолтойг сайтар ойлгож, ухаарч байсныг илтгэн харуулж байгаа юм”¹⁰ хэмээн тэмдэглэсэн бол Оросын эрдэмтэн Арсений Николаевич Чанышев (1926-?) цэгцтэй хялбаршуулан бичсэн “Аристотель” (М., 1981, 1987) хэмээх товхимолдоо “Аристотель практикийн эрдэм ухаан болсон ёс зүй, түүн лүгээ нягт холбогдсон улс төрийн ухааныг онолын, бясалгагч эрдэм ухаанаас эрс ялгасан юм. Практикийн эрдэм ухаан бол үйл ажиллагааны тухай, авир үйлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг хүний үйлдэж буй чөлөөт сонголттой холбогдсон үйлдэхүйн тухай эрдэм ухаан юм”¹¹ гэсэн байна.

Судалгааны зорилго: Сэдвийн дагуу Аристотелийн зохиолууд дундаас “Дээд суртахуун” зохиолыг сонгон авч агуулга, ач холбогдлыг шинжлэхийг зорилгоо болгов.

Аристотелийн ёс суртахууны тухай зохиолууд нь зөвхөн онолын гэхээсээ илүү практик эрдэм ухааны шинжтэй хийгээд хүний үйлдэл, хариуцлага, амьдралын зөв сонголтын гэх мэт ёс зүйн олон асуудлуудыг илэрхийлэн хүн ба нийгмийн ёс суртахууны үндсийг гүнзгий тусган илэрхийлжээ. Түүний “Дээд суртахуун” зохиолд “Платон... “Төр улс” зохиолдоо ... зүй ёсны тэнцвэрт чанарыг хэрэглэсэн нь тодорхой байна. Тэрбээр хэлэхдээ, тариачин тариа хураадаг, барилгачин байшин барьдаг, оёдолчин цув оёдог, гуталчин гутал хийдэг; ингээд тариачин барилгачинд тариагаа өгдөг, барилгачин нь тариачинд байшин өгнө, цаашаагаа ийм маягаар өөрт байгаа юмаа бусдад байгаа юмтай солилцох харилцаанд ордог. Үүнд тэнцэл оршино, тодруулбал барилгачин нь тариачинтай яаж харьцаж буй шигээр тариачин барилгачинтай тийм харилцаанд орно. Үүн шигээр гуталчин, оёдолчин болон бусад бүх хүмүүсийн хооронд харилцааны адил ижил тэнцэл оршиж байдаг, чухам энэхүү тэнцвэрт чанар дээр нийгмийн амьдрал тогтдог. Ингээд үзэхлээр, шударга зүйл гэдэг бол тал талаасаа тэнцвэрт зүйл мөн; нийгмийн амьдрал шударга ёсон дээр тогтдог, харин шударга ёс нь аанай л тал талаасаа тэнцвэртэй байх чанар юм”¹² гэсэн буй. Энд Аристотель Платоны төр улс зохиолоос ишлэн авч, шударга ёс түүний уг мөн чанарын тухай авч үзсэн. Зохиолын агуулгаар хот улс, улс төрийн нэг нэгж модус болж байдаг хүний амьдрал ба нийгмийн бүтэц, шударга ёсны ойлголт нь хоорондоо нарийн хэлхээ холбоотой ба тогтолцооныхоо хувьд бүхэлдээ тэнцвэр, зохицол дээр үндэслэгдэн тогтдог болохыг тодорхойлжээ. Нийгэм улс төрийн үндсэн бүтэц нь шударга ёсон дээр тогтдог ба энэ нь нийгмийн харилцаанд оролцож буй түүнээс хамааралтай бүх элементүүдийг тэнцвэртэй байдлаар зохицуулах замаар илэрхийлэгддэг гэсэн үг. “Дээд суртахуун” зохиолын эхэнд л Аристотель ёс зүйн тодорхойлолтыг

¹⁰ Б.Оюунчимэг. Ёс зүй, ёс суртахууны тухай ном. УБ., 2019. Тал 34.

¹¹ А.Н.Чанышев. Аристотель. Орчуулсан УБ., 2010. Ёс зүй (14)

¹² Аристотель. Дээд суртахуун. Тэргүүн дэвтэр (А) (33). Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. УБ., 2011. Тал 52-53.

өгөхдөө түүнийг шууд нийгэм-улс төрийн утга холбогдолтой болохыг тодотгон “Ёс зүй бол төр улсынхаа бүрэлдэхүүн хэсэг юм. ... ёс суртахууны тодорхой чанаргүй хүнийг, тухайлбал тэнцэхгүй хүнийг улс төр-олон нийтийн ажил үйлсэд оролцуулах огт хэрэггүй”¹³ хэмээсэн.

Нийгэм-улс төрийн амьдрал нь харилцан өөр хоорондоо хамааралтай маш олон бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын нарийн нийлмэл харилцааны үндсэн дээр бий болж, оршин тогтдог ба түүний нэгж модус болох хүн тус бүр өөр өөрийн нийгмийн харилцан хамааралтай орчинг ёс суртахууныхаа тусламжтайгаар бүрдүүлнэ. Харилцан хамааралтай энэ орчин тэнцвэртэй, шударга байх нь маш чухал. Хүмүүстэй харилцахдаа шударга байна гэдэг нь угтаа тэгш ёс юм. Энэ тухайд уг зохиолд “Хэрэв шударга зүйл гэдэг нь тэгш байдаг юм бол тал талаасаа тэгш тэнцүү байх нь бас шударга зүйл болно. Тэгш тэнцвэрт чанар гэдэг наад зах нь дөрвөн гишүүнтэй байдаг, юу гэвэл А бол Г нь Д гишүүнд харьцаж буйтай адилаар В гишүүнд харьцах ёстой. Жишээ нь, их хөрөнгөтэй нь их хандив (татвар) өгнө, багатай нь бага өгнө, энэ нь их ажилласан нь их авч, бага ажилласан нь бага авдагтай дүйцдэг, үүнд л тал талаасаа тэгш тэнцүү байх учир оршдог. Ажилсаг нь залхуутай ямар харьцаанд байдаг шиг (Ажилсагийн авч буй нь их, залхуугийн авч буй нь бага) багад тийм харьцаатай байдаг, тэгээд ажилсаг нь (авч буй их зүйлдээ) харьцдаг шигээр залхуу нь (авч буй бага юмандаа) харьцдаг”¹⁴ гэсэн нь А юмуу Г тал буюу нэг эсвэл нэг хэсэг тал нь илүү давамгайлах юм бол нийгэмд тэнцвэр алдагдах бөгөөд шударга ёсыг тогтооход хүндрэл үүсэх ба тухайн нийгэм улс төрийн амьдралын үндсэн зарчмуудыг зөв бүрдүүлэх бололцоогүй болох юм. Энэ утгаараа нийгмийн хэсэг бүр, хот улсын модус нэгж иргэн бүр тус бүр өөрсдийн үүргийг зөв биелүүлж, хоорондоо тэнцвэртэй ёс зүйн харилцаа үүсгэснээр зөв амьдрах, төр улс бат бөх байх, эрчимтэй хөгжих боломжтой байна гэсэн санаа агуулагдаж байна. Үүгээр Аристотель шударга ёс нь зөвхөн хууль эрх зүйгээр биш, иргэдийн хоорондын ёс суртахууны тэнцвэртэй харилцаанд, зөв зохицолтой байх тэгш хэмд илэрдэг гэсэн санааг хэлэхийг хүссэн. Өөрөөр хэлбэл нийгэм-улс төрийн амьдрал нь ёс суртахууны хувьд тус тусын үүргээ биелүүлж, хоорондоо тэнцвэртэй байдлаар харилцах хүмүүсийн хооронд буй болдог зүйл хийгээд энэ тэнцвэр нь аль нэг талын эрх мэдэл, нөөцийн илүүдэлд бус, харин бүх талуудын хувьд тэнцвэртэй хуваарилалт, шударга харилцаанд суурилах ёстой. Тиймээс л дээр хэлснээр шударга ёс зөвхөн хууль дүрмээр бус, эдгээр тэнцвэрт харилцаануудыг бий болгоход оршиж байдаг аж.

Аристотелийн “Дээд суртахуун” зохиол нь ёс зүйн нэр томъёонуудын нэвтэрхий тайлбар толь хэлбэртэйгээр зохиогдсон хийгээд нэгж тус бүрийн нарийвчилсэн тайлбарыг хийхдээ зохиогч түүний амьдралын нарийн мөн чанарт орших практик эрдэм ухааныг илүү ихээр анхаарсан байна. Зохиолын тэргүүн дэвтрийн (А) 34 хэсэгт ёс зүй, сайн сайхан, сэтгэл санаанд байгаа сайн сайхан, сайн үйл, сэтгэл санаа, харуусал цэнгэл, сэтгэл санааны гүнд юу оршиж байна,

¹³ Аристотель. Дээд суртахуун. Тэргүүн дэвтэр (А) (1). Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. УБ., 2011. Тал 20.

¹⁴ Аристотель. Дээд суртахуун. Тэргүүн дэвтэр (А) (33). Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. УБ., 2011. Тал 52.

дундаж, дундажид илүүдэх, дутуудах, анхны эхлэл, хүн, сайн дураар гаргах үйл авир, эх захгүй хүн, албадлага, гарцаагүй байдал, зорго бус, чөлөөт сонголт, оюун ухаан, үлэмж сайхан, эр зориг, тохитой ухаан, тогтуун зан, өгөөмөр чанар, харамч хомхой, уужим сэтгэл, бэлэрхүү зан, тэчъяадал, зохимжийг мэдрэх, даруу зан, алиа зан, найрсаг зан, үнэнээрээ байхуй, шударга ёс, эрүүл мэнд гэх мэт ёс зүйн нэр томъёонуудын гүн нарийн утга учрыг бодит амьдрал, практик эрдэм ухаанд гочлон тулгуурлаж тайлбарласан буй.

Эдгээр нэршлүүдийг тайлбарлахдаа Аристотель хүний амьдралын утга учир, ёс суртахууны үүрэг ач холбогдол, хүний зан чанар болон түүнд сэтгэл санааны байдал хэрхэн нөлөөлдөг тухайд, хүний сайн муу үйлдлүүд нийгэмд хэрхэн оршихуйг нь илэрхийлж, улс төр, нийгмийн уг чанарыг тодорхойлдог тухайд, сайн үйлд тулгуурлан хүн бүрийн амьдралд эерэг өөрчлөлтийг авчрах, зөв замаар амьдрах, бусдыг хүндлэх, шударга ёс хэрэгжүүлэх, өөрийгөө хөгжүүлэх, уужим сэтгэлтэй байж бусдын эрх чөлөөг хүндэтгэх, сайн сайхан үйлс хийх зэргийг уриалж, хүний амьдралын ёс суртахууны мөн чанарыг философийн үүднээс тодорхойлохыг хүссэн. Ингэхдээ тэр хүн хэмээх төрөл зүйлийг ёс суртахууны үүднээс, нийгмийн нэг нэгж болох утгаар нь дотоод мөн чанараас нь эхлэн нэвтэрхий тайлбарлаж, түүний сайн муу үйлийн үр дүн нь улс төрийн мөн чанарыг эцсийн дүндээ илэрхийлдэг тухай олон талаас бичсэн. Энд нэгэн жишээнд “... төр улсын амьдралд зөвөөр оролцъё гэж бодож байгаа тэр этгээд сайн үйлийн дээд суртахуунтай хүн байвал зохино. Тэгээд бодохлоор ёс зүй бол улс төрийн нэг хэсэг, нэг эхлэл нь болж түүнд багтан ордог. Ер нь миний бодлоор бол, энэ судлагдахууныг ёс зүй гэх бус, харин улс төрийн ухаан хэмээн нэрлэх нь илүү зөв юмаа”¹⁵ гэж бичжээ.

Аристотелийн “Дээд суртахуун” зохиолын тэргүүн дэвтрийн (А) 34 хэсгийн ёс суртахууны нэр томъёонуудын тайлбараас үзэхэд уг зохиол бүхэлдээ дээд суртахуунт хүн ямар байх тухай олон талаас нь бүрэн дүүрэн дэлгэрэнгүй өгүүлсэн хийгээд зохиолыг уншин ухаарсан судлагч, хүн хэмээгч зөвхөн биологийн амьтан биш тэр хүн төрөлхтний түүхийн туршид хуримтлагдсан ёс зүй, зан чанар, оюун санаа, сэтгэл хөдлөл, амьдралын утга учир, үнэт зүйлсийг ойлгож, тэдгээрийн дагуу амьдарч чаддаг, оюун ухаан, сэтгэл зүрхний “Алтан дундаж” тэнцвэрийг хадгалдаг, бусдад эерэг нөлөө үзүүлж, зөв үйлдлүүдийг хийх чадвартай “Улс төрийн амьтан” юм гэдгийг ухааран ойлгохоор байна. Иймээс ёс зүйн шинжлэх ухааны эх ундрага болсон энэхүү бүтээлийг дээд боловсрол эзэмшихээр зорин буй залуучууд, сонсогч, оюутан хэн бүхэн заавал судлан ойлгох үндсэн эх сурвалж болгож хэрэглэх нь зөв зүйтэй санагдана. Зохиолд хүний зөв буруу, сайн муугийн ялгаа, түүний хэм хэмжээний дунджийг гүнзгий танин мэдэх, шударга ёс, өгөөмөр зан, хүндлэл, итгэл үнэмшил, өршөөл, зөөлөн сэтгэл, ёс суртахууны зөв зүг чигийг баримтлах, амьдралдаа зөв сонголт хийх шийдвэр гаргах, бусдын эрхийг хүндэтгэх зэрэг ёс зүйн өндөр дээд суртахууны стандартуудыг иргэн хүн дагах хэрэгтэй тухай тодорхой өгүүлсэн.

¹⁵ Аристотель. Дээд суртахуун. Тэргүүн дэвтэр (А) (1). Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. УБ., 2011. Тал 20.

Шинэлэг тал: Орчин үед ч гэсэн хувь хүний ёс суртахуун нь оршин буй нийгэмтэйгээ зөв харилцах, хүмүүстэй зөв харилцаа тогтоох, бусдын эрхийг хүндэтгэж шударга хөдөлмөрлөн сайшаал хүлээн амьдрах эх үндэс болдог. Амьдралдаа зөв сонголтуудыг хийн өөрийн сэтгэл санааны тэнцвэрийг хадгалж, үүрэг хариуцлагаа ухамсартайгаар биелүүлэн, амьдарч буй орчноо хүндэтгэх нь түүний ёс суртахууны төлөвшил, хөгжлийн нэг хэсэг юм. Тиймээс дээд суртахуун нь хүний оюун санааны өндөр түвшин, нийгмийн амьдралд эзлэх байр суурийг бататгах үндэс болдог тухай оновчтой тайлбарласан Аристотелийн “Дээд суртахуун” зохиол нь өнөө үед ч гэсэн шинэ утгаар өөрийн үнэ цэнэ, ач холбогдолоо огтхон ч алдаагүй хэвээр байна.

Дүгнэлт

Аристотелийн “Дээд суртахуун” зохиолын агуулга, ач холбогдлыг авч үзвэл дараах дүгнэлт хийж болох ба үүгээр үл хязгаарлан олон талаас нь дахин давтан давтан судлах, үнэ цэнэ, ач холбогдлыг залуучуудад тайлбарлан таниулах шаардлага байна. Үүнд:

- “Дээд суртахуун” зохиолын агуулгаас үзэхэд Аристотель ёс суртахууныг практик эрдэм ухааны чадвар юм гэдгийг түлхүү гаргажээ. Эл зохиолд ёс суртахууны асуудлыг философи сэтгэлгээний аргаар нарийвчлан шинжлэн судалж, энэ үндсэн дээрээ улс төрийн амьтан болох хүн гэж юу болохыг цогцлоон харуулжээ.
- Зохиол зөвхөн ёс суртахуун тухайд биш цаагуураа нийгэм-улс төрийн олон утга санаануудыг хадгалж байна. Энэ нь зохиолд төр ба улс төрийн холбогдолтой олон хэсгүүд байгаа хийгээд тэдгээрийн агуулгаас бүрэн харагдана. Иймээс уг зохиолыг улс төрийн шинжлэх ухааны талаас нь бас судлах нь ач холбогдолтой бөгөөд шаардлагатай зүйл юм. Мөн үүгээр эс тогтож энэ зохиолыг хүн судлал, сэтгэл судлал, хэл шинжлэлийн гаргууд судалгаа юм гэж дүгнэх бүрэн боломжтой.
- Аристотелийнхаар бол хүн улс төрийн үйл ажиллагаанд оролцож төрийг удирдахын тулд эхлээд дээд суртахууны агуулгыг сайн мэдэж бодит байдалд өөрөө түүнийг бүрэн дүүрэн эзэмшсэн, сэтгэл, зан авир, суртахууны тухай их мэдлэгтэй байвал зохино гэжээ.
- Аристотель зөвхөн энэ зохиолд бус “Улс төр”, “Реторика”, “Туурвил зүй” зэрэг өөр олон зохиолууддаа ёс суртахууны талаар өөрийн санаагаа бичиж байсан байна. Мөн зарим зүйл дээр үзэл санаа зөрдөг ч Платоны нийгэм-улс төрийн сургаал түүний зохиол бүтээлүүдэд нөлөөлсөн. Иймээс Аристотелийн ёс зүйн сэтгэлгээний мөн чанарыг бүрэн дүүрэн ойлгохын тулд Платоны үзэл санааг зэрэгцүүлэн судлах нь ихээхэн ач холбогдолтой.
- “Дээд суртахуун” зохиолд Аристотель ёс суртахууны асуудлуудыг боловсруулахдаа хүн ба улс төрийн харилцааны мөн чанар, агуулгыг тодорхойлон гаргасан. Төр улсын уг мөн чанарыг оновчтойгоор тайлбарлахад түүнд ёс зүйн асуудлаарх философийн судалгаа нь томоохон тус дэм болжээ. Америкийн улс төрийн философич Лео Штраус ёс зүйн талаарх Аристотелийн бүтээлүүдийг үнэлж “Бид Аристотелийн “Ёс зүйг” (Энд түүний “Дээд суртахуун” ба ёс зүйн сэдвээрх бусад хоёр бүтээлийг

хэлж байна) илүү төгөлдөр гэж, эсхүл хамгийн оновчтой ойлгомжтой философижсон ёс зүй юм гэж үзэж болно”¹⁶ хэмээн бичиж үлдээсэн.

- Аристотель бол гярхай судлаач шинжээч байсан бөгөөд ёс суртахууны үндсэн нэр томъёонуудыг маш нарийн хэлдэг, үзэгдэл юмс, ойлголтод тодорхойлолт өгөхдөө нэн гарамгай байсан ба өөрийн гэсэн судалгааны өвөрмөц аргуудтай байсан бололтой. Зохиол бүтээлүүд нь өөр хоорондоо нягт уялдаа холбоотой ба бүгдийн үндсэнд ёс суртахууны асуудал ямар нэг хэмжээгээр шингэсэн санагдлаа. Тухайлбал миний уншин судалсан хүрээгээр “Улс төр”, “Реторика”, “Дээд суртахуун” ба ёс зүйн сэдвээрх бусад хоёр бүтээл ёс суртахууны агуулгаар хоорондоо бат холбоотой байна.

Эш татсан сурвалж, судалгааны бүтээлийн жагсаалт

- [1] Аристотель. Улс төр., Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. I боть. УБ., 2011.
- [2] Аристотель. Улс төр. УБ., 2015.
- [3] А.Н.Чанышев. Аристотель. М., 1981, 1987; Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. I боть. УБ., 2011.
- [4] Аристотель. Дээд суртахуун., Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. УБ., 2011.
- [5] Аристотель. Уран илтгэхүйн ухаан., Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. III боть. УБ., 2011.
- [6] А.Цанжид. Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2010.
- [7] Б.Оюунчимэг. Ёс зүй, ёс суртахууны тухай ном. УБ., 2019.
- [8] И.Өлзийсайхан. Аристотелийн “Rhetorica” зохиолын агуулгад хийсэн шинжилгээ. ЭШӨ. МУИС-ийн Улаанбаатар сургууль. Нийгмийн ухааны факультет. Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн эрдэм шинжилгээний эмхэтгэл №2(1). УБ., 2011.
- [9] Философи. Сурах бичиг. УБ., 2002.
- [10] Ш.Ганхуяг, М.Гантуяа. Философийн түүхэн тойм. УБ., 2002.